



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 214

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2017 оны 86 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Автотээврийн үндэсний төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 73,980,000.00 (далан гурван сая есөн зуун наян мянган) төгрөгийн балансын үнэ, 5,137,500.00 (таван сая нэг зуун гучин долоон мянга таван зуун) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 103,868,250.00 (нэг зуун гурван сая найман зуун жаран найман мянга хоёр зуун тавин) төгрөгийн балансын үнэ, 98,819,367.77 (ерэн найман сая найман зуун арван есөн мянга гурван зуун жаран долоон төгрөг далан долоон мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг "Автотээврийн үндэсний төв" улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

3.Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, "Автотээврийн үндэсний төв" улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал П.Дэлгэрнаран, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, хууль зүйн хэлтсийн дарга А.Ариунболд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:


3.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

3.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

3.3.Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.


4.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

 Б.ГАНБАТ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

 А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 05 дугаар сарын 21-ны өдрийн
2019/05/21 дугаар тогтоолын хавсралт

"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР, ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, БАЛАНСААС БАЛАНСАД
ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, марк	Ашиглалтад орсон огноо	Нийт гүйлт (км)	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)	Шилжүүлэх хуулийн этгээд	Шилжүүлэн авах хуулийн этгээд
1	Хьюндай соната lf, 05-56 УБУ (kmhe241cbka504476)	2018.12.17	9602	73,980,000.00	5,137,500.00	68,842,500.00	"Автотээврийн үндэсний төв" УТҮГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
2	Мерседес бенз, 15-35 УНУ (wdd2120481a423534)	2018.12.21	41844	103,868,250.00	98,819,367.77	5,048,882.23	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	"Автотээврийн үндэсний төв" УТҮГ
	Нийт дүн			177,848,250 (нэг зуун далан долоон сая найман зуун дөчин найман мянга хоёр зуун тавин)	103,956,867.77 (нэг зуун гурван сая есөн зуун тавин зургаан мянга найман зуун жаран долоон төгрөг далан долоон мөнгө)	73,891,382.23 (далан гурван сая найман зуун ерэн нэгэн мянга гурван зуун наян хоёр төгрөг хорин гурван мөнгө)		